



УЛААНБААТАР ХОТЫН  
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН  
ТУШААЛ

2019 оны 01 сарын 02 өдөр

Дугаар 1/03

Улаанбаатар хот


Төрийн бус байгууллагыг ажиллуулах тухай

Төсвийн тухай хуулийн 16.5.5, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын нийтийн эзэмшлийн гудамж, цэцэрлэгийн ногоон байгууламжийн өвөлжилтийг хангах зорилгоор мод, сөөгийг цасаар манаж дулаалах, том оврын нарс модны гол ишийг таараар ороож, шилмүүсийг утаа тортоогоос хамгаалж хучлагаар хучих, хучлага болон том оврын нарс модны гэрэлтүүлгийн асалтын бүрэн бүтэн байдлыг хангах, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдээр орчны явган хүний зам, талбайн цас мөсний цэвэрлэгээг хийлгэх, уг ажлын биелэлтэд хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах ажлыг нийгэмд үйлчлэх Төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.


2. Төрийн бус байгууллагыг гэрээгээр ажиллуулахад шаардагдах хавсралтад дурьдсан нийт 10.000.000 /Арван сая/ төгрөгийг Ногоон байгууламжийн арчилгааны зардлаас гаргахыг ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

3. Төрийн бус байгууллагын ажлын явц, биелэлтэд хяналт тавьж, тайлагнаж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР  
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ  
ДАРГА  Т.ГАНТӨМӨР



Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн  
2019 оны 07 сарын 03 өдрийн  
... тушаалын хавсралт



### ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ

| д.д | Зардлын нэр  | Тоо хэмжээ | Нэг бүрийн зардал /төгрөг/ | Хугацаа /сар/ | Нийт зардал /төгрөг/ |
|-----|--|------------|----------------------------|---------------|----------------------|
| 1.  | Ажилтнуудын цалин                                      | 6 хүн      | 600.000                    | 2             |                      |
| 2.  | Бичиг хэрэгсэл, утас, унаа, хоол, татвар, бусад зардал | 6 хүн      | 234.000                    | 2             | 7.200.000            |
|     |  |            |                            |               | 2.800.000            |
|     | Дүн /төгрөг/   |            |                            |               | 10.000.000           |